МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
**эрдэм шинжилгээний бичиг**
Тот. XXXIV (360) 2012 (220-224)

# Ж. БАТГЭРЭЛИЙН *"БҮТЭЦ ХЭЛ ШИНЖЛЭЛ"* НОМЫН ТУХАЙД

Ж. Баянсан*

Профессор Батгэрэлийн энэ бүтээл нь уламжлалт хэлшинжлэл, бүтэц хэлшинжлэл гэсэн 2 үндсэн хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр нь хэд хэдэн бүлгээс бүрдсэн байна. Жишээлбэл: Уламжлалт хэлшинжлэл хэмээх эхний хэсгийн түүхэн тойм хэмээх 1-р бүлгийн агуулгыг тоймлон үзвэл: Эртний Энэтхэгийн хэлшинжлэлийн уламжлал, Эртний Грекийн хэлшинжлэлийн уламжлал, Эртний Римийн хэлшинжлэлийн уламжлал, Дундад зууны хэлшинжлэл, XVI-XVIII зууны хэл шинжлэл, Дундад зууны монгол хэлшинжлэл гэсэн агуулгатай байна.

Тэрээр өрнө болон дорно дахины хэлшинжлэлийн уламжлалд Дундад зууны монгол хэлшинжлэлийг биеэ даасан нэг хэсэг болгон багталцуулсан нь монгол хэл шинжлэлч нарын түүхэн үзэл онолыг дэлхийн хэлшинжлэлийн хараанд аваачсан сонирхолтой гаргалга гэж үзэж болно.

Дундад зууны монгол хэлшинжлэл гэдэг хэсэгтээ Сажибандида Гунгаажалцан /1182-1251/ зохиосон *"Зүрхний толт"*, Пагва лам Лодойжалцан зохиосон /1235-1280/ *"Дөрвөлжин үсэг"*, Чойжий Одсэрийн зохиосон *"Зүрхний толт"*-ыг уламжлал хэлшинжлэлийн түүхэн тоймын төлөөлөл болгон товчоолж бичсэн байна.

I бүлгийн 2-р хэсэг нь 19-р зууны түүхэн хэлшинжлэлийн асуудлыг авч үзэхэд зориулсан байна. Үүнд Яков Гримм, Карл Вернер, Вильгельм Гумбольдт нарын хэлний тухай үзэл баримтлалыг авч үзсэн бол залгаад хэлшинжлэлийн натуралист дэг сургууль шинэ хэлшинжлэлийн дэг сургууль, сэтгэц, нийгэм хэлшинжлэлийн дэг сургууль, хэлийг марксист үзлийн үүднээс авч үзэх нь гэсэн хэсгүүдийг багталцуулсан байна.

I бүлгийн 3-р хэсгээ *"Орчин үеийн хэл шинжлэл"* гэжээ. Үүнд Соссюрын хэлшинжлэлийн онол, Соссюрын онолын тогтолцоо, Соссюрын хэлшинжлэлийн онолын онцлог буюу ач холбогдол гэсэн хэсгүүдийг багтаасан байна. Учир нь Батгэрэлийн ном *"Бүтэц хэлшинжлэл"* гэдэг нэртэй бөгөөд чухамдаа уг асуудалд гол асуудлаа төвлөрүүлэх зорилготой байснаас *"Бүтэц хэлшинжлэл"* хэмээх 2-р бүлгийн агуулгын угтал болгон Соссюрын хэлшинжлэлийн үзэл онолыг энэ хэсгийнхээ залгаа болгон өгүүлсэн гэж үзмээр байна. Бидний танилцуулан буй бүтээлийн энэхүү 2-р бүлэг нь тоо, чанарын аль ч талаараа уг бүтээлийн үндсэн хэсэг болох бөгөөд дотроо 6 хэсгээс бүтсэн байна. 1-р хэсэг нь Прагийн хэлшинжлэлийн дугуйланг авч үзсэн бол 2-р хэсэг нь Данийн хэл шинжлэл буюу Копенхаген хэлшинжлэлийн уламжлал 3-р хэсэг нь Америкийн товчоолох хэлшинжлэл, 4-р хэсэг нь Ноам Чомскийн хувиргал ба үүсгүүр хэлзүй, 5-р хэсэг нь Лондоны хэлшинжлэл 6-р хэсэг нь танин мэдэхүйн хэлшинжлэл гэсэн агуулгыг тус тус багталцуулжээ.

---

* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор, профессор

Профессор Батгэрэлийн уг бүтээлийн агуулгыг дахин нэг анхааралтай ажиглавал хэлшинжлэлийн сургаал, дэг сургууль, үзэл онолын Европид үүсэн төлөвшсөн чиг хандлагуудыг тоймлон гаргах байдалтай зохиосон сурах бичиг юм уу гэтэл арай тийм биш, чухамдаа хэлний үзэгдэл баримтын хэлбэрийн бүтэц буюу *"цэвэр"* бүтэц, агуулгын бүтэц хоёрын аль алиныг бүтэц хэлшинжлэл хэмээх агуулгад нэг чиг бүхий хараагаар нэгтгэн түүхчилж үзүүлэхийг зорьсон гэмээр байна. Ялангуяа 2-р бүлгийн сүүлийн 3-н хэсэг нь агуулгын хувьд 1970 хэдэн оноос Оросод хэвлэгдсэн, бид оюутандаа сурах бичиг болгон ашиглуулдаг хэлшинжлэлийн түүхийн сурах бичгийнхээс нэлээд өвөрмөц болсныг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал тус бүлгий 2-р хэсэгт Бронислав Малиновский, Жон Руберт Пирс нарын хэлшинжлэлийн үзэл баримтлал, М.А.К Халидайн хэлшинжлэлийн үүргийн бүтэц, хэлний нийгмийн үүргийн тухай үзэл онолыг онцгойлон авч үзсэний дээр 6-р хэсэг нь танихуйн хэлшинжлэлийн бүтэц, концепт түүний арга зүйн үндэс, танихуйн хэлшинжлэлийн агуулгын бүтэц бодот юмс, хэлний хоорондын харьцаа хамаарлыг, таних тухай асуудал мөн танихуйн хэлшинжлэлийг судалгааны аргазүйн чиглэл болгохын ач холбогдлыг тус тус товчоолон өгүүлсэн нь сонирхолтой болсон байна. Мөн 2-р бүлгийн 4-р хэсэг нь бүхэлдээ Ноам Чомскийн хувиргал хэлзүйн бүтцийг үүтгэл болгож түүний үзэл баримтлалыг 1957-1965 оны буюу сонгодог онолын үе, 1965-1971 оных буюу стандарт онолын үе, 1972-1979 оных буюу стандарт онолын өргөтгөлийн үе гэж ялган зааглаж тодорхойлсон нь чухамдаа өөрийнхөө бүтээлийг бүтэц хэлшинжлэл /онолын цогц ба одоохи байдал/ хэмээн нэрлэсэнтэй агуулгын хувьд нийцэж байна.

Профессор Батгэрэлийн энэ бүтээл нь их, дээд сургуулийн хэлбичгийн ангид сурч байгаа суралцагч нарт хэлний тухай шинжлэх ухаан эртний ба дундад үеийн төлөв байдал, мөн орчин үеийн хэлшинжлэлийн түгээмэл дэг сургуулийн гол гол төлөөллийн тухай зохих мэдээлэлтэй болж түүнийгээ дэлгэрүүлэн гүнзгийрүүлэхэд хэрэгтэй гарын авлага болсон гэж үзэж байна.

Харин хэлшинжлэлч нарын үзэл онолын агуулгын цөм, мөн чанарыг илэрхийлсэн үг хэллэг, нэр томьёог монголоор оноохын тухайд бидний хооронд ялгаатай зүйл цөөнгүй дайралдаж байна. Гэвч профессор Батгэрэл өөрийн оноосон нэр томьёо, томьёололын ард тухайн хэлшинжлэлчийн оноосон нэрлэлтийг латин юмуу англи хэлээрх хэлбэрээр нь хадаж өгсөн нь энэ ялгаатай байдлыг зөв таньж ухаарахад дөхөмтэй болсныг тэмдэглэх хэрэгтэй. Жишээлбэл: Батгэрэл *behaviourism*-ийг үйлийн үзэл, *code of language* –ийг хэлний дадхал , *dianoetic*-ийн мөрдлөгийн онол, *learning theory*-хэлний дадхалын асуудал гэх зэргээр тайлбарлан оноосон байна. Түүнчлэн *distribution* –ийг бид байрлал гэж оноодог бол Батгэрэл тархац гэж оноосон байна.

**Хавсралт - 1**

Баруун Хойтын Үндэсний Их Сургуулийн профессор Ж. Батгэрэлийн *"Бүтэц хэлшинжлэл"* номын агуулга

# Contents


**Foreword** ............................................................ (1)

**Introduction** ............................................................ (1)

## Part One Traditional Linguistics

**Chapter One Historical Overview** .............................. (3)

Ⅰ Ancient Indian Linguistics .............................. (3)

1. The Content and Ideas of *Panini's Grammar* .............. (5)
2. The Influences and Meanings of *Panini's Grammar* .............................. (10)

Ⅱ Ancient Greek Linguistics .............................. (12)

Ⅲ Ancient Roman Linguistics .............................. (18)

Ⅳ Linguistics of the Middle-Age .............................. (20)

Ⅴ 16th to 18th Century Linguistics .............................. (25)

Ⅵ Mongolian Linguistics of the Middle-Age .............................. (29)

1. Sa Skya Pandita kun-dgav-rgyal-mtshan(1182 — 1251) and his "Jirüken-ü toltu" .............................. (30)
2. hp'ags-pa Lama Lodoì Jaltsan (1235 — 1280) and his Square Script .............................. (37)
3. Čhos-kyi 'od- zer and his "Jirüken-ü toltu" .............. (43)

**Chapter Two 19th Century Historical Linguistics** .............. (49)

Ⅰ Historical Linguistics in the Early Days of the


1

2. The Content and Ideas of Leonard Bloomfield's *"About language"* ...... (203)
Ⅳ Charles F. Hockett and his *Modern Linguistics*, Text Book ...... (208)
1. The Content of the *Text Book* ...... (209)
2. The Innovations in the *Text Book* ...... (212)
**Chapter Four Noam Chomsky and his Transformational Generative Grammar** ...... (215)
Ⅰ The Structure of Noam Chomsky's Transformational Generative Grammar ...... (218)
Ⅱ The Formation Period in Noam Chomsky's Transformational Generative Grammar ...... (223)
1. Period of Classical Theories (1957—1965) ...... (223)
2. Period of Standard Theories (1965—1971) ...... (233)
3. Period of Extended Standard Theories (1972—1979) ...... (240)
4. The Significance of Noam Chomsky's Linguistic Theories ...... (245)
**Chapter Five The London Language School** ...... (247)
Ⅰ Structure and Theory of the London Language School ...... (248)
Ⅱ Branislaw Malinowski's View on Language ...... (251)
Ⅲ John Rupert Firth's View on Language ...... (253)
Ⅳ M. A. K. Halliday and the Structural Function of Linguistics ...... (255)

Ⅴ M. A. K. Halliday and the Social Function of Language ...... (260)
**Chapter Six Cognitive Linguistics** ...... (263)
Ⅰ Concept and Structure of Cognitive Linguistics ...... (264)
Ⅱ Methodology in Cognitive Linguistics ...... (267)
Ⅲ Content Structure in Cognitive Linguistics ...... (268)
1. Cognition of the Relationship Between Language and Objective Things ...... (269)
2. The Significance of Research on Cognitive Linguistics ...... (271)
**References** ...... (273)
**Appendix** ...... (281)

19th Century ······ (50)
1.Jacob Grimm, About Language ······ (53)
2.Karl Verner, About Language ······ (56)
3.Kart Wilhelm Von Humboldt. About Language ······ (57)
Ⅱ Comprehensive Linguistics ······ (62)
1.The Naturalist School of Linguistics ······ (63)
2.New Linguistic Schools ······ (66)
3.Psycho- Socio Linguistic' School ······ (70)
4.Views of Marxist Linguistics ······ (71)
**Chapter Three Modern Linguistics** ······ (73)
Ⅰ Ferdinand De Saussure's Linguistic Theories ······ (76)
Ⅱ Ferdinand De Saussure's Theoretical System ······ (81)
Ⅲ The Significance of Ferdinand De Saussure's Linguistic Theories ······ (110)

## Part Two Structural Linguistics

**Chapter One The Prague Linguistics Circle** ······ (118)
Ⅰ Concept and Structure of Prague Circle ······ (119)
Ⅱ Theoretical System and Structure of Functional Linguistics ······ (121)
1. The Comparison of Neogrammarian School and Prague Circle ······ (121)
2. Prague Circle's Views on Language ······ (128)



Ⅲ Phonological Rules ······ (137)
Ⅳ Distinctive Features ······ (143)
1. Distinctive Features of Phoneme ······ (145)
2. Distinctive Features of Sememe ······ (154)
**Chapter Two Copenhagen Linguistics** ······ (164)
Ⅰ Concept and Structure of Copenhagen Linguistics ······ (164)
Ⅱ Theoretical System of Copenhagen Linguistics ······ (166)
Ⅲ Views on Copenhagen Linguistics ······ (170)
1. Preliminary Period of Linguistic Symbols (1928—1935) ······ (171)
2. Formation Period of Linguistic Symbols (1935—1945) ······ (172)
**Chapter Three American Descriptive Linguistics** ······ (178)
Ⅰ Theoretical System of American Descriptive Linguistics ······ (183)
1. W.D.W. Hitney's *"About language"* ······ (183)
2. Franz Boas' view on Language ······ (185)
3. The Significance of Franz Boas' Language Study ······ (190)
Ⅱ Edward Sapir's *"About language"* ······ (191)
1. Edward Sapir's View on Linguistics ······ (192)
2. Edward Sapir's Influence on Linguistics Theory ······ (195)
Ⅲ Leonard Bloomfield's *"About language"* ······ (196)
1. The Formation of Bloomfield's Linguistic Theories ······ (197)